

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Хангал сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/85/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг  
2022 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд  
Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр  
Утас: 7034-2580 Цахим хаяг: [ankhbayard@audit.gov.mn](mailto:ankhbayard@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 7034-2716 Цахим хаяг: [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

Аудитор: Г.Цэрэнлхам  
Утас: 7034-2495 Цахим хаяг: [Tserenlkhamg@audit.gov.mn](mailto:Tserenlkhamg@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал .....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт .....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	19

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
БУА	Булган аймаг
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 87  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

ХАНГАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Л.САЙНГЭРЭЛ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хангал сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хангал сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


D:/bichighereg/2022A4toot

006020145

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichihereg/2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>121,311,715.92</b>	<b>189,587,306.11</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	530,000.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	530,000.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	530,000.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	530,000.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	39,211.47	1,591,500.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	39,211.47	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	1,591,500.00
3351	Байгууллагаас авах авлага	-	1,591,500.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	121,272,504.45	187,465,806.11
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	111,718,504.45	177,229,806.11
35410	Бичиг хэргийн материал	4,345,294.00	4,548,849.00
35420	Аж ахуйн материал	15,230,269.40	31,084,246.06
35430	Сэлбэг хэрэгсэл	13,771,150.00	17,513,150.00
35440	Түлш, шатах тослох материал	1,678,360.00	452,100.00
35470	Бусад хангамжийн материал	76,693,431.05	123,631,461.05
35600	Мал амьтад	9,554,000.00	10,236,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,059,277,218.12</b>	<b>1,004,184,470.06</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,059,277,218.12	1,004,184,470.06
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,052,720,418.12	998,179,369.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	894,201,176.44	900,066,176.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	(169,997,936.04)	(198,410,254.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	192,487,750.00	168,449,750.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(117,170,808.19)	(123,429,233.21)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	124,188,065.00	128,435,864.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(29,755,734.07)	(49,371,123.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	85,671,638.00	92,358,638.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(52,653,294.05)	(59,549,993.22)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	90,000,000.00	90,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	44,357,473.15	64,476,773.15
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,607,912.12)	(14,847,227.04)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	6,556,800.00	6,005,100.12
39301	Програм хангамж	2,256,800.00	2,256,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(551,699.88)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,300,000.00	4,300,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,180,588,934.04</b>	<b>1,193,771,776.17</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,180,588,934.04</b>	<b>1,193,771,776.17</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,180,588,934.04	1,193,771,776.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	245,829,377.90	245,829,377.90

51101	Өмч: - төрийн	245,829,377.90	245,829,377.90
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>907,508,696.67</b>	<b>920,691,538.80</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	907,508,696.67	907,508,696.67
51220	Тайлант үеийн үр дүн	-	13,182,842.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	27,250,859.47	27,250,859.47
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,180,588,934.04</b>	<b>1,193,771,776.17</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>398,513,226.37</b>	<b>576,714,470.25</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>20,034,500.00</b>	<b>64,148,885.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	20,034,500.00	64,148,885.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,034,500.00	64,148,885.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	584,500.00	556,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,450,000.00	63,592,385.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>378,478,726.37</b>	<b>512,565,585.25</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	35,339,650.00	70,498,362.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	8,941,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагадаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,820,800.00	16,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,118,850.00	4,302,562.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	400,000.00	41,254,800.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	343,139,076.37	442,067,223.25
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	308,679,647.37	409,665,723.25
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	34,459,429.00	32,401,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>425,018,708.91</b>	<b>521,672,776.38</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>425,018,708.91</b>	<b>521,672,776.38</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	404,169,508.91	520,750,560.13
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	222,145,539.00	210,392,969.00
210101	Үндсэн цалин	152,364,248.00	146,680,621.00
210102	Нэмэгдэл	49,029,000.00	59,762,557.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,752,291.00	3,949,791.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27,916,282.90	27,318,960.81
210201	Тэтгэврийн даатгал	19,136,872.40	19,033,028.69
210202	Тэтгэмжийн даатгал	2,253,600.37	2,115,378.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,802,121.28	1,692,303.12
210204	Ажилгүйдлийн даатгал	427,608.55	422,233.57
210205	Эрүүл мэндийн даатгал	4,296,080.30	4,056,016.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12,626,868.00	122,510,768.60
210301	Гэрэл, цахилгаан	2,692,498.00	3,274,821.60
210302	Түлш, халаалт	9,934,370.00	117,095,947.00

210303	Цэвэр, бохир ус	-	2,140,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,634,506.00	16,264,190.00
210401	Бичиг хэрэг	1,534,346.00	1,640,465.00
210402	Тээвэр, шатахуун	10,137,650.00	11,965,635.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,229,360.00	1,389,340.00
210404	Ном, хэвлэл	-	94,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	774,850.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	418,150.00	399,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	315,000.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	203,700.00	178,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	203,700.00	178,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,804,500.00	732,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	30,000.00
210604	Урсгал засвар	4,804,500.00	702,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,560,000.00	1,861,000.00
210702	Дотоод албан томилолт	1,560,000.00	1,861,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	13,401,975.00	3,824,009.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,550,800.00	320,030.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	298,400.00	888,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	124,775.00	361,979.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	104,000.00	154,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,100,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	107,876,138.01	137,667,662.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,883,719.60	51,196,482.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	516,400.00	164,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,476,018.41	86,307,180.32
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	20,849,200.00	922,216.25
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	20,849,200.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,649,200.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	922,216.25
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	922,216.25
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(26,505,482.54)</b>	<b>55,041,693.87</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	8,556,000.00	6,450,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	8,556,000.00	6,450,000.00
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	31,480,508.44	48,308,851.74
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	9,395,708.44	46,926,666.74
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	22,084,800.00	1,382,185.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(22,924,508.44)	(41,858,851.74)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(49,429,990.98)</b>	<b>13,182,842.13</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	245,829,377.90	27,250,859.47	907,508,696.67	1,180,588,934.04
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	245,829,377.90	27,250,859.47	907,508,696.67	1,180,588,934.04
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	13,182,842.13	13,182,842.13
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	245,829,377.90	27,250,859.47	920,691,538.80	1,193,771,776.17

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>379,063,226.37</b>	<b>513,122,085.25</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>584,500.00</b>	<b>556,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	584,500.00	556,500.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	584,500.00	556,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	584,500.00	556,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>378,478,726.37</b>	<b>512,565,585.25</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	35,339,650.00	70,498,362.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	8,941,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,820,800.00	16,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,118,850.00	4,302,562.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	400,000.00	41,254,800.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>343,139,076.37</b>	<b>442,067,223.25</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	308,679,647.37	409,665,723.25
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	34,459,429.00	32,401,500.00

2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>352,098,326.37</b>	<b>459,225,186.25</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>352,098,326.37</b>	<b>459,225,186.25</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>331,249,126.37</b>	<b>456,711,470.00</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	222,145,539.00	210,392,969.00
210101	Үндсэн цалин	152,364,248.00	146,680,621.00
210102	Нэмэгдэл	49,029,000.00	59,762,557.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,752,291.00	3,949,791.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27,955,494.37	27,279,749.34
210201	Тэтгэврийн даатгал	19,176,083.87	18,993,817.22
210202	Тэтгэмжийн даатгал	2,253,600.37	2,115,378.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,802,121.28	1,692,303.12
210204	Ажилгүйдлийн даатгал	427,608.55	422,233.57
210205	Эрүүл мэндийн даатгал	4,296,080.30	4,056,016.64
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	8,042,918.00	122,802,754.66
210301	Гэрэл, цахилгаан	2,692,498.00	2,992,607.66
210302	Түлш, халаалт	5,350,420.00	116,900,147.00
210303	Цэвэр, бохир ус	-	2,910,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,032,620.00	18,528,126.00
210401	Бичиг хэрэг	1,685,200.00	1,879,800.00
210402	Тээвэр, шатахуун	9,806,060.00	9,586,605.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,286,360.00	1,704,120.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	4,832,101.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	255,000.00	525,500.00
2105	<b>Нормативт зардал</b>	587,100.00	2,124,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	587,100.00	2,124,200.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,277,700.00	10,909,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	577,100.00
210604	Урсгал засвар	5,277,700.00	10,332,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,560,000.00	1,861,000.00
210702	Дотоод албан томилолт	1,560,000.00	1,861,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	14,423,075.00	3,789,659.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,571,900.00	285,680.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	298,400.00	888,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	124,775.00	361,979.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	104,000.00	154,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,100,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	38,224,680.00	59,023,912.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,698,280.00	58,331,912.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	526,400.00	692,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>20,849,200.00</b>	<b>2,513,716.25</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	20,849,200.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,649,200.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	2,513,716.25
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,513,716.25
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>26,964,900.00</b>	<b>53,896,899.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>26,964,900.00</b>	<b>53,366,899.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>26,964,900.00</b>	<b>53,366,899.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	26,964,900.00	53,366,899.00
222001	Тоног төхөөрөмж	15,599,900.00	3,517,899.00
223001	Бусад хөрөнгө	11,365,000.00	49,849,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(26,964,900.00)</b>	<b>(53,366,899.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	530,000.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	530,000.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>			
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	428,026,100.00	441,701,507.00	(13,675,407.00)
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	428,026,100.00	425,436,607.00	2,589,493.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	428,026,100.00	425,436,607.00	2,589,493.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	189,259,400.00	210,392,969.00	(21,133,569.00)
210101	Үндсэн цалин	131,897,400.00	146,680,621.00	(14,783,221.00)
210102	Нэмэгдэл	48,254,700.00	59,762,557.00	(11,507,857.00)
210105	Гэрээт ажлын хөлс	9,107,300.00	3,949,791.00	5,157,509.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	25,550,000.00	27,279,749.34	(1,729,749.34)
210201	Тэтгэврийн даатгал	17,979,600.00	18,993,817.22	(1,014,217.22)
210202	Тэтгэмжийн даатгал	1,892,600.00	2,115,378.79	(222,778.79)
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,514,100.00	1,692,303.12	(178,203.12)
210204	Ажилгүйдлийн даатгал	378,500.00	422,233.57	(43,733.57)
210205	Эрүүл мэндийн даатгал	3,785,200.00	4,056,016.64	(270,816.64)
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	122,451,300.00	119,642,754.66	2,808,545.34

Булган аймгийн Хангал сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	5,800,600.00	2,992,607.66	2,807,992.34
210302	Түлш, халаалт	116,650,700.00	116,650,147.00	553.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,351,800.00	14,198,475.00	(846,675.00)
210401	Бичиг хэрэг	1,209,800.00	1,629,800.00	(420,000.00)
210402	Тээвэр, шатахуун	7,660,200.00	8,839,055.00	(1,178,855.00)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,456,800.00	1,704,120.00	(247,320.00)
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,500,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,525,000.00	525,500.00	999,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	600,000.00	504,200.00	95,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	504,200.00	95,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	17,532,000.00	10,909,100.00	6,622,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	577,100.00	5,422,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,532,000.00	-	7,532,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	10,332,000.00	(6,332,000.00)
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,857,000.00	1,861,000.00	1,996,000.00
210702	Дотоод албан томилолт	3,857,000.00	1,861,000.00	1,996,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,333,600.00	3,789,659.00	7,543,941.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,501,900.00	285,680.00	7,216,220.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	888,000.00	888,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	365,700.00	361,979.00	3,721.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154,000.00	154,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,100,000.00	2,100,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	44,091,000.00	36,858,700.00	7,232,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,541,000.00	36,166,700.00	7,374,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,000.00	692,000.00	(142,000.00)
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	386,453,100.00	410,222,223.25	(23,769,123.25)
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	386,053,100.00	409,665,723.25	(23,612,623.25)
132001	Орон нутгийн төсвөөс	386,053,100.00	409,665,723.25	(23,612,623.25)
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	400,000.00	556,500.00	(156,500.00)
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400,000.00	556,500.00	(156,500.00)
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	-
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-

<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>23.00</b>	<b>23.00</b>	<b>-</b>
620001	Удирдах ажилтан	6.00	6.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00	-
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00	-
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>23.00</b>	<b>23.00</b>	<b>-</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8.00	8.00	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5.00	5.00	-
650010	Гэрээт ажилтан	4.00	4.00	-
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6.00	6.00	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	Зөрүү
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>			
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	68,376,862.00	(68,376,862.00)
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	31,274,863.00	(31,274,863.00)
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	31,274,863.00	(31,274,863.00)
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	3,160,000.00	(3,160,000.00)
210302	Түлш, халаалт	-	250,000.00	(250,000.00)
210303	Цэвэр, бохир ус	-	2,910,000.00	(2,910,000.00)
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	4,329,651.00	(4,329,651.00)
210401	Бичиг хэрэг	-	250,000.00	(250,000.00)
210402	Тээвэр, шатахуун	-	747,550.00	(747,550.00)
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	3,332,101.00	(3,332,101.00)
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	1,620,000.00	(1,620,000.00)
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,620,000.00	(1,620,000.00)
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	22,165,212.00	(22,165,212.00)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	22,165,212.00	(22,165,212.00)
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	37,101,999.00	(37,101,999.00)
2200	Дотоод эх үүсвэрээр	-	37,101,999.00	(37,101,999.00)
222001	Тоног төхөөрөмж	-	699,999.00	(699,999.00)
223001	Бусад хөрөнгө	-	36,402,000.00	(36,402,000.00)
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	70,498,362.00	(70,498,362.00)
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	70,498,362.00	(70,498,362.00)
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	8,941,000.00	(8,941,000.00)
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс	-	16,000,000.00	(16,000,000.00)

	тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө			
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,302,562.00	(4,302,562.00)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	41,254,800.00	(41,254,800.00)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	530,000.00	(530,000.00)

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хангал сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлангийн толилуулга, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор Г.Цэрэнлхам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хангал сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/49 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

МУ-ын засгийн газрын болон аймаг сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар сум, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу тайлант онд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хангал сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 231,019.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,465.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,425.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хангал сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	530.0	530.0
Авлага	39.2	1,591.5	(1,552.3)
Бараа материал	121,272.5	187,465.8	(66,193.3)
Үндсэн хөрөнгө	1,059,277.2	1,004,184.5	55,092.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,180,588.9</b>	<b>1,193,771.8</b>	<b>13,182.9</b>
Богино хугацаат өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	245,829.4	245,829.4	
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,180,588.9</b>	<b>1,193,771.8</b>	<b>13,182.9</b>

/мянган төгрөг/

Тайлант хугацаанд орон нутгийн төсвөөс 442,067.2 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 70,498.4 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 556.5 мянган төгрөгийг бүрдүүлэн нийт 513,122.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 510,078.4 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулан, 2,513.7 мянган төгрөгийг төвлөрүүлэн, нэмэлт санхүүжилтийн 530.0 мянган төгрөг эцсийн үлдэгдэлтэй байна.

Авлага тайлант хугацаанд 1,591.5 мянган төгрөг болж, 1,552.3 мянган төгрөгөөр өссөн нь иргэдийн өгсөн хандив гүйлгээ хаагдсаны дараа орж ирсэнээс нэмэлт санхүүжилтийн дансанд авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 187,465.8 мянган төгрөг болж 66,193.3 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материалын дансанд ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор маск, ариутгалын бодис, нэг удаагийн хувцас, мөн ОНХСан, СХСангийн хөрөнгөөр бэлтгэсэн бусад хангамжийн материалыг шилжүүлэн авсанаас нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,004,184.5 мянган төгрөг болж 55,092.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр тавилга, программ хангамж, бусад үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж бэлтгэж, сум хөгжүүлэх сангаас хэвлэгч, орон нутгийн сангийн эх үүсвэрээс хийгдсэн хөрөнгө оруулалтаар ёслол хүндэтгэлийн өргөө, авто машины зам зэргийг шилжүүлэн авч, акталсан Ланд круйзер-200 автомашиныг данснаас хассанаас нөлөөлсөн байна.

Тайлант хугацаанд 706,498.8 мянган төгрөгийн өглөг үүсгэж, бүрэн барагдуулан хугацааны эцэст өглөггүй ажилласан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнрүү бичилт хийгдээгүй, тайлант оны хуримтлагдсан үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээнд өөрчлөлт ороогүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 413,969.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 49,521.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 463,491.2 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн тодотголоор төсвийн захирагчийн төсөвт өөрчлөлт ороогүй байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн 6 чиглэлийн арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 442,067.2 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 556.5 мянган төгрөгийн нийт 442,623.7 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 751,903.7 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, 1,004.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг зөрчил гаргаад хураагдсан автомашиныг борлуулсны орлого, хөрөнгө борлуулсны орлого, буудлын орлогоос бүрдүүлэн, урсгал үйл ажиллагаанд 423754.3 мянган төгрөгийг зарцуулж, 329,153.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 751,903.7 мянган төгрөг буюу 101.3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 11,465.2 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 2,367.8 мянган төгрөгөөр буюу 7.1 хувиар, байр

ашиглалттай холбоотой зардал 2,299.6 мянган төгрөгөөр буюу 4.6 хувиар, эд хогшил, урсгал засварын зардал 3,104.3 мянган төгрөгөөр буюу 16.1 хувиар, хангамж, бараа материалын зардал 2,312.8 мянган төгрөгөөр буюу 10.3 хувиар, томилолт зочины зардал 2,267.8 мянган төгрөгөөр буюу 52.7 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн, ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 363.3 мянган төгрөгөөр буюу 11.8 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 88,942.4 мянган төгрөг буюу 70.8 хувиар тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр орлого дараах эх үүсвэрээс бүрдсэн байна. Үүнд:

- Ковид-19 цар тахалтай холбоотойгоор урьдчилан сэргийлэх зардалд 5,000.0 мянган төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс, 1,000.0 мянган төгрөгийг аймгийн Гамшгаас хамгаалах сангаас,
- Төрөөс хариуцах цэвэр бохир усны төлбөрийн хөнгөлөлт 5,868.0 мянган төгрөгийг Булган мээж ХХК-иас,
- Хамтарсан багийн сургалтын зардалд 300.0 мянган төгрөгийг аймгийн ИТХ-аас,
- Хагас жилийн мал тооллогын зардалд 433.7 мянган төгрөг, мэдээлэл цуглуулах судалгааны зардал 50.0 мянган төгрөгийг нийт 483.7 мянган төгрөгийг Статистикийн хэлтсээс,
- Нэр бүхий 10 өрхийн хүнсний дэмжлэгт 500.0 мянган төгрөгийг, ХГБХЗХөгжлийн газраас,
- Гурван эвэртэйн замын засварын зардалд 10,000.0 мянган төгрөгийг аймгийн Авто замын сангаас,
- Хог хаягдал ачихаар 3,150.1 мянган төгрөгийг Бридж констракшин ХХК-аас
- Морин эргүүл хийх зардалд 748.8 мянган төгрөгийг аймгийн Байгаль хамгаалах сангаас,
- Хуучин авто машиныг шинэчлэхээр 31,712.5 мянган төгрөгийг ЗДТГ-ын Ланд-200 авто машиныг борлуулсны орлогоос,
- Нэр бүхий 25 иргэнээс 8,791.0 мянган төгрөгийн хандив,
- Спорт заалны цагийн түрээсийн төлбөрийн 2,252.3 мянга, ухаалаг худгын карт борлуулсны орлого 492.0 мянга, шар байрны түрээсийн орлого 200.0 мянган төгрөгөөс тус тус бүрдсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив 8,941.0 мянга, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилагдсан хөрөнгө 4,302.6 мянга, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 41,254.8 мянган төгрөг, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 16,000.0 мянга нийт 70,498.4 мянган төгрөгийн орлого хүлээн авсан байна.

Түлш халаалтын зардалд 250.0 мянга, цэвэр бохир усны зардалд 2,910.0 мянга, бичиг хэргийн зардалд 250.0 мянга, тээвэр шатахууны зардал 747.6 мянгад, хог хаягдал зайлуулах зардалд 3,332.1 мянга, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардалд 1,620.0 мянга,

бараа үйлчилгээний бусад зардалд 22,165.2 мянга, биет ба биет бус хөрөнгө худалдан авахад 37,101.9 мянга нийт 69,968.4 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Үндсэн хөрөнгийн 39201, 39203, 39205, 39207, 39214 дансанд 69 нэр төрлийн 78,052.4 мянган төгрөгийн хөрөнгө эзэмшилдээ байгаа элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох шаардлагатай байна. Үлдэх өртөг тэг үлдэгдэлтэй ашиглалтын хугацаа бүрэн дууссан хөрөнгөнд нэмж элэгдлийн зардал байгуулагдахгүйгээс тухай тайлант хугацааны элэгдлийн зардал үнэн зөв илэрхийлэгдэхгүй дутуу тайлагнагдаж байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 128 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба сар бүр 96 мэдээлэл, улирал бүр 4 мэдээлэл оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

- ✚ Шилэн дансны нэгдсэн [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлээгүй нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй,

- ✚ Мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж баталгаажуулаагүй нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй,

- ✚ Дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих дотоод хяналт хангалтгүй нь дотоод хяналтын талаарх Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын холбогдох заалттай нийцээгүй,

- ✚ Аудитаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүн болох 93,361.3 мянган төгрөгөөс 10 хувь буюу 9,336.1 мянган төгрөгийн хэмнэлт гаргахаар төлөвлөж тооцоогүй нь МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д ".....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож,

урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасан шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгсөнийг Хангал сумын ЗДТГ-ын даргын 2021 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн 03/315 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Биелэлтийг тооцож үзэхэд шатахууны зарцуулалтын талаар байгууллагын удирдлагуудад танилцуулан ЗГ-ын 2019 оны 390 дүгээр тогтоолоор баталсан жишиг нормоос авто машины хянаж, энэ онд баримтлан ажилласан байна. Мөн бүх хөрөнгийн элэгдлийг бүрэн бодуулж, нийгмийн даатгалын хэлтэстэй тооцоо нийлсэн акт үйлдэж, шилэн дансны мэдээллийг тухай бүрд нь мэдээлж ажилласан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Өөрийн эзэмшилдээ байгаа боловч хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн ашиглалтын хугацаа дууссан ч ашиглагдаж байгаа хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн шинэчлэн тогтоох, нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулалтын эрх нээхдээ Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөлтийг оновчгүй хийж байгаа учраас шар байрны түрээсийн орлого, спорт заалны цагийн түрээсийн төлбөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар авч зарцуулж байна.

Мөн Сумын ИТХ-ын хуралдаанаар төсөв батлахдаа ЗДТГ-ын орон тоог 18 байхаар баталсан нь "Сумдын засаг даргын тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай" Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоолоор 3001-5000 хүртэл хүн амтай суманд 16 байхаар байтал 2 орон тоогоор илүү цалингийн зардлыг баталж байгаад анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 300,392.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 109,641.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 190,750.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмж өгсөн.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн үр дүнгийн тайланд 92,982.4 мянга, мөнгөн гүйлгээний тайланд 2,023.2 мянга, бараа материалын тодруулга тайланд 14,636.3 мянган төгрөг нийт 109,641.9 мянган төгрөгийн алдааг тусгаж баталгаажуулав.

Энэ нь УСНББОУС 27-д "санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", "Үнэн зөв толилуулга" нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг", НББОУС 8-ын 10.Б.1-д "аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, санхүүгийн гүйцэтгэл ба мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлэх" заалтуудтай нийцэхгүй, "эрх ба үүрэг", "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

### **4.2 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 4.3 Албан шаардлага

4.3.1 Нормын хувцас зөөлөн эдлэлийн данснаас 220.0 мянган төгрөгийн тугны суурь тавилга, багаж техникийн худалдан авах зардлаас 12 нэр төрлийн 6,687.0 мянган төгрөгийн ширээ сандал, кресль сэйф шкаф зэргийг конторын тавилга бэлтгэсэн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэхь заалтыг хэрэгжүүлээгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байгаад Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчин тавилга эд хогшил бэлтгэсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

4.3.2 Таван сая төгрөгөөр дээш үнийн дүнтэй худалдан авалтын мэдээлэл буюу 35,962.0 мянган төгрөгийн Ланд-100 авто машины 1 мэдээллийг мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш 146,636.3 мянган төгрөгийн 12 гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"-д заасныг тус тус хэрэгжүүлээгүйд шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах, шилэн дансанд хугацаанд нь мэдээллийг иж бүрэн байршуулж, гарсан зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлагыг тус тус хүргүүлээ.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. **Бараа материал данстай холбоотой асуудал**

##### 1.1. Илрүүлэлт:

Бичиг хэргийн материалд дансанд ном, бусад хангамжийн материал, аж ахуйн материал болон үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бүртгэж, дансны ангилал буруу бүртгэсэн байна. Энэ нь УСНББОУС 17, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалт болон "ангилал" батламж мэдэгдлийг хэрэгжүүлээгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

УСНББОУС 17, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

#### 2. **Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал**

##### 2.1. Илрүүлэлт:

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүн болох 93,361.3 мянган төгрөгөөс 10 хувь буюу 9,336.1 мянган төгрөгийн хэмнэлт гаргахаар төлөвлөж тооцоогүй байна.

##### 2.2. Өгсөн зөвлөмж:

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д ".....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалтыг хэрэгжүүлэн, Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол болон МУЗГ-аас баталсан төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлж байгаа шийдвэрүүдийг мөрдөж ажиллах.

#### 3. **Дотоод хяналттай холбоотой асуудал**

**3.1. Илрүүлэлт:**

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу 2020-2021 хичээлийн жилд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж ажиллаагүй байна.

**3.2. Өгсөн зөвлөмж:**

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж, дотоод хяналт шалгалтын баг томилуулан ажиллуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Хангал сумын ЗДТГ	14	300,392.4	9	109,641.9	0	0	2	190,750.5	3	0